“Анхан болон давж заалдах шатны шүүхийн
Тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журам”-ын
2 дугаар хавсралт

# ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

## НЭГ. УДИРТГАЛ

**1.1.** Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**1.2.** Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**1.3.** Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн жилд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

## ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

**2.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

**2.1.1.** шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэргийн хөдөлгөөний нэгдсэн системд хэрэг хуваарилах журмын дагуу бүртгэх, шилжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.2.** хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аргачлал, журмын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.3.** шүүгчийн шүүн таслах ажиллагааны ачааллыг судлах, хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр судалгаа хийж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.4.** шүүн таслах ажиллагааны талаарх бусад мэдээллийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулах, уг зөвлөгөөний шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээ авах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.5.** шүүн таслах ажиллагааны статистик, тайланг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж, Ерөнхий зөвлөлд хүргүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.6.** хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавих, улирал, хагас, бүтэн жилээр тоон мэдээлэл гаргаж шүүхийн цахим хуудаст байршуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.7.** шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүх хуралдааны тов, тоймыг тухай бүр цахим систем /www.live.shuukh.mn/-д байршуулж шүүхийн цахим хуудаст мэдээлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.8.** хэргийн оролцогчийг зайнаас буюу цахимаар шүүх хуралдаанд оролцуулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.9.** шүүхийн шийдвэрийг цахим хуудас /www.shuukh.mn/-т холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд байршуулах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.10.**шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл, эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг холбогдох байгууллага, иргэнд тухай бүр хүргүүлэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.11.**шүүн таслах ажлын төрлөөр холбогдох мэдээллийг бүртгэл, хяналтын нэгдсэн системд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрээр цаг тухайд нь оруулж, бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах, хэргийн хөдөлгөөний нэгдсэн системийг шүүгч, шүүхийн захиргааны ажилтан ашиглах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.12.**хавтаст хэрэг илгээх, хүлээж авах журмын дагуу хэрэг, баримтыг шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.13.**шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шалгаруулах, сонгохтой холбоотой журмыг хэрэгжүүлэх, шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.14.**иргэдийн төлөөлөгчийг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.15.**иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд товын дагуу оролцуулах ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.16.**иргэдийн төлөөлөгчид зориулсан сургалтыг Ерөнхий зөвлөлөөс баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, гарын авлагаар хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.17.**шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.18.**эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм, журмыг хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.19.**шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах нөхцөлийг хангах, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.20.**эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.21.**эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар шүүхэд хүргүүлэхэд хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.22.**шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд шүүхийн программ хангамж ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.23.**шүүхэд мэдээллийн технологийг ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, шүүхийн үйл ажиллагааг

цахимжуулах ажлыг Ерөнхий зөвлөлийн нэгдсэн бодлогын хүрээнд зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.24.**шүүхийн программ хангамж, техник хангамж, сүлжээний аюулгүй байдлыг хангах, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.25.**шүүх хуралдааны явцыг дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулж, архивлах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.26.**шүүхийн цахим хуудасны хэвийн ажиллагааг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.27.**компьютер, хувилагч, хэвлэгч, хяналтын камер болон бусад тоног төхөөрөмж, дотоод, гадаад болон интернэт сүлжээний хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах, эрсдэлийн үнэлгээ хийх, техник хангамжийн бүртгэл хөтлөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.28.**шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтлөхөд мэдээллийн технологийн дэвшилтэт программ хангамжийг ашиглах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.29.**шүүхийн нэгдсэн сүлжээг ашиглах техникийн бололцоог бүрдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.30.**шүүхийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, кибер халдлага, хортой код, спам, вирусээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.31.**иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу хуваарилж, шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гаргаж Ерөнхий шүүгчид танилцуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.32.**шуудангийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.33.**архивт хадгалбал зохих хэрэг, баримт бичгийг хүлээн авах, данс, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж, баримт нягтлан шалгах орон тооны бус комиссын үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.34.**хадгаламжийн нэгжийг хууль, журам, заавар, стандартын дагуу хадгалах, хамгаалах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, иргэн, хуулийн этгээдэд архивын үйлчилгээ үзүүлэх**,** тогтоосон хугацаанд үзлэг, тооллого хийх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.35.**шүүхийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг Ерөнхий зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.36.**шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, аюулгүй байдлыг хангасан шүүхийн байрны нийтлэг журмын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.37.**шүүхийн байр, шүүх хуралдааны танхим, өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжийн болон хуралдаан, бусад үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.38.**шүүхээр үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, ахмад настан, насанд хүрээгүй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.39.**хэргийн эд мөрийн баримтыг шүүхэд хүлээж авах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, буцаан олгох, устгах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.40.**хэргийн эд мөрийн баримт устгах комиссыг зохих журмыг баримтлан томилон ажиллуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.41.**гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед тухайн шүүхийн үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлэх, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн үйлчилгээг хүргэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.42.**Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл болон холбогдох бусад байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажлын уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох, ирүүлсэн хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд тодорхой санал өгөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.1.43.**шүүхийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

-Дүн шинжилгээ

**2.2. Шүүхийн хүний нөөцийг удирдах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

**2.2.1.**Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан бүтэц, орон тооны дагуу тухайн шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэх, бүртгэл, мэдээллийн сан хөтлөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.2.**төрийн албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.3**.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах, тайлагнах хүрээнд авч хэрэгжүүсэн арга хэмжээ

**2.2.4.**шүүхийн захиргааны хүний нөөцийг сургаж чадавхжуулах, чадахуйн зарчмын дагуу шатлан дэвшүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх, ажлын ачааллыг судлан хүний нөөцийн төлөвлөлт, хуваарилалт, хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.5.**шүүгчийн тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.6.**шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, амь нас,

эрүүл мэндийн даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.7.**шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг шагналд тодорхойлох, уламжлах ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.8.**шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг албан томилолтоор ажиллуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.9.**шүүхийн захиргааны ажилтнуудад чөлөө олгох асуудлыг Монгол Улсын шүүхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад журамд заасны дагуу шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.10.**шүүхийн захиргааны ажилтанд цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг зохих журмын дагуу тогтоож олгох хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.11.**шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэхэд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хуулийг баримтлах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.12.**шүүхийн захиргааны ажилтны мэдлэг, чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитой үнэлж дүгнэх, урамшуулж идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.13.**шүүхийн захиргааны ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үнэлж, дүгнэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.14.**төрийн албан хаагчийн болон шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөвлөл байгуулан ажиллуулах, ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, ажлын цаг ашиглалтад хяналт тавих хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.15.**шүүхийн ахмадуудын болон шүүгч, шүүхийн захиргааны ажилтны холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.2.16.**шүүхийн хүний нөөцийн программ ашиглах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**-**Дүн шинжилгээ

**2.3. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

**2.3.1.**шүүгчийн хараат бус, аюулгүй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх, санал, зөвлөмж гаргаж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.2.**шүүх хуралдааны аюулгүй байдлыг зохих журам, стандартын дагуу хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.3.**шүүгчээс хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэлийг холбогдох журамд заасны дагуу нууцлалыг хангаж, Ерөнхий зөвлөлд хүргүүлэх, нөлөөллийн

мэдүүлэгт нотлох баримт бүрдүүлэхэд шүүгчид дэмжлэг үзүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.4.**Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүн, аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох нөхцөл байдал бий болсон бол Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.5.**шүүгчид хууль ёсны эрх ашгаа хамгаалахаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад тайлбар, хүсэлт гаргах, нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх ба шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт гаргасан бол Ерөнхий зөвлөлд уламжлах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.6.**шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд уг шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг дангаараа, эсхүл Ерөнхий зөвлөлийн ажлын алба /цаашид “Ажлын алба” гэх/-тай хамтран хуульд заасан хэлбэрээр авч хэрэгжүүлэх, хэрэв уг арга хэмжээг дангаар авч хэрэгжүүлсэн бол Ажлын албанд тухай бүр шуурхай мэдэгдэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.7.**шүүгчийг хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах тусгай хэрэгслээр хангаж, хэвийн ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах, зааварчилгаа өгөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.8.**шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх талаар тогтоосон журмыг баримтлан шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.9.**шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг эрэн сурвалжлах талаар хэрэгжүүлж байгаа ажилд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээ авах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.10.**шүүх, шүүхийн байрны гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, байгалийн аюулт үзэгдэл, осол, гамшиг гарах үед холбогдох арга хэмжээг цагдаагийн байгууллага болон шаардлагатай тохиолдолд бусад хууль сахиулах байгууллагатай хамтран хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.11.**шүүхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой техник хэрэгсэл суурилуулах, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, онцгой нөхцөлд ажиллах

ажилтны нэрс, ажлын зааврыг батлах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд урьдчилан танилцуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.12.**шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд сургалт зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.13.**шүүгчийн хүсэлтийг үндэслэн түүний амьдарч байгаа орон байр нь галын аюулгүй байдал, гэмт халдлагаас хамгаалагдсан эсэхэд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.3.14.**шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

-Дүн шинжилгээ

**2.4. Шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

**2.4.1.**шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, стандартын дагуу үндэслэлтэй боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, шийдвэрлүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.2.**батлагдсан төсвийг зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай зарцуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.3.**батлагдсан цалингийн сан, орон тоонд багтаан ажиллаж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны цалин болон татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, өр, авлагагүй ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.4.**санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргах, төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээ, тайлан, судалгаагаар хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.5.**Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.6.**худалдан авах ажиллагаар /www.tender.gov.mn/ цахим хуудсыг ашиглан, ил тод, нээлттэй байлгаж, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.7.**Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд /www.shilendans.gov.mn/ цахим хуудаст үнэн зөв, иж бүрэн байршуулж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.8.**төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох дүрэм, журам, зааврыг сахин биелүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.9.**шүүхийн эд хөрөнгийг хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн бүртгэх, нягтлан бодох бүртгэлийн программаас хэвлэсэн эд хариуцагчийн картыг эд хөрөнгөтэй тулган тооллого хийх, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.10.**шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, албан тасалгааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлыг батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.11.**шүүхийн эд хөрөнгийг шинээр бүртгүүлэх, бүртгэлээс хасах, ашиглалтын хугацаа дууссан, хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах, устгах саналыг төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.12.**шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, гарын авлага, бичиг хэрэгслийн болон бусад шаардлагатай материалаар хангах ажлыг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.13.**шүүхийн автомашин, тоног төхөөрөмж, барилга байгууламжид засвар үйлчилгээг цаг хугацаанд нь тогтмол хийх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.14.**тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг, тооллогод бэлтгэх, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.15**.шүүхийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, эрүүл мэнд, нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татварын тайланг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, баталгаажуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**-**Дүн шинжилгээ

**2.5. Мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

**2.5.1.**шүүхийн цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах, мэдээллийн шуурхай, хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.2.**Тамгын газрын хүний нөөц, шүүхийн үйлчилгээний болон санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.3.**шүүхийн үйлчилгээний төрөл, шаардагдах баримт бичгийн жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.4.**шүүх хуралдааны зар, тоймыг тухай бүр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, шинэчлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.5.**тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх

шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг цахим хуудаст байршуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.6.**иргэдийн төлөөлөгчийн оролцоо, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нэгдсэн мэдээллийг улирал бүр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, тухай бүр шинэчлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.7.**нэхэмжлэлийн загвар, бүрдүүлбэр, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх банкны дансны дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, тухай бүр шинэчлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.8.**Тамгын газрын үйл ажиллагааны жилийн тайланг өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.9.**шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулах ажлыг зохион байгуулах, иргэд, хэвлэл мэдээллийн ажилтныг шүүх хуралдааны дэгд заасны дагуу оролцуулах боломжоор хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.10.**нээлттэй шүүх хуралдааны үйл явцыг олон нийт ажиглах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.11.**шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.12.**төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.13.**шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг нэгдсэн аргачлалын дагуу зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.4.14.**Ерөнхий зөвлөлийн шийдвэрийг шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад мэдээлэх, хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**2.5.15.**тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны талаар мэдээлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**-**Дүн шинжилгээ

## ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

## ДӨРӨВ. ХАВСРАЛТ

**4.1.** Тамгын газрын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

**4.2.** Тухайн жилийн үйл ажиллагааны тайланд шүүгч, ажилтны өгсөн үнэлгээ /хурлын тэмдэглэл/ шүүгч нарын зөвлөгөөний тогтоол

# НЭГ. УДИРТГАЛ

**1.1.** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д төрийн үйл ажиллагааг үе шаттай бүрэн цахимжуулах зорилтыг тавьсан бөгөөд үүнтэй уялдуулан Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлагдсан.

Тус шүүхийн тамгын газраас Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшүүлэх” зорилтын хүрээнд тус шүүхийн хараат бус байдлыг хангуулах, шүүхийн үйлчилгээг хариуцлагатай явуулах, иргэд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ хүрээнд харъяа тойргийн 9 суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, шүүх, шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгч, тус шүүхийн шүүн таслах ажиллагааны талаарх тоон мэдээллийг өөрийн шүүхийн веб сайт болон фейж хуудсанд байршуулан ажиллаж байна.

Шүүхийн үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлын хүрээнд тухайн сумын Ерөнхий боловсролын 1, 2-р сургууль болон МСҮТөвийн ахлах ангийн 47 сурагчдыг шүүхийн үйл ажиллагаатай танилцуулж, шүүгчтэй зөвшилцөн зөрчлийн хэргийн нээлттэй хуралдаанд оролцуулан шүүн таслах ажиллагааны талаар мэдлэг мэдээлэл олгож байна.

Тойргийн сумдаар ажиллаж буй Эвлэрүүлэн зуучлагч болон мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, шүүгчийн туслахууд шүүхийн талаарх мэдээ, мэдээлэл болон шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, шүүхэд нэхэмжлэл гаргах талаар холбогдох сургалт, мэдээллийг тогтмол хийж шүүхийн үйл ажиллагаа, нээлтэй байдлын талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан нэгдсэн аргачлалын дагуу зохион байгуулан ажиллалаа.

**1.2.** Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд дэвшүүлж буй шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагаанд инновац, мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэр нэвтрүүлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдэж, ажлын бүтээмж, үр дүн бодитой хэмжигдэх, хүний нөөцийн чадавх сайжирах, шүүхийн захиргааны үйл ажиллагаа цаасан сууринаас цахимд шилжих зэрэг үйл ажиллагаанд идэвхи зүтгэлтэй оролцох боломжийг эрэлхийлж, Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг өөрийн шүүхэд тусган хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

**1.3.** 2023 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн **“Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх”** зорилгын хүрээнд 5 зорилтын дэвшүүлэн 56 ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж, тухай бүр хэрэгжүүлэн ажиллалаа.

# ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

## 2.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ




2.1.1. Нийт шүүгчийн чуулганы 2021.10.11-ний өдрийн 05 дугаартай тогтоолоор баталсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”-ын 2.3, тус шүүхийн 2022.12.26-ны өдрийн 01 дугаартай “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол”-ын “Шүүхэд иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах шүүгчид хуваарилах журам”, ШЕЗ-ийн 2022.02.24-ний өдрийн 41 дугаартай тогтоолоор баталсан “Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах журам”-ын 6.4, ШЕЗ-ийн 2022.03.04-ний өдрийн 52 дугаартай тогтоолоор баталсан “Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-ын 3.5, 4.1, 4.2.1, 4.3, 4.7, 4.8, 7.4.1, 7.7.1, 7.10.1, 7.10.2-т тус тус заасны дагуу хэрэгжилтийг хангаж нийт 290 нэхэмжлэл, хяналтын шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан 1 хэрэг, шүүгчийн захирамжид гаргасан гомдол 4, давж заалдах гомдол 7, хяналтын гомдол 6, даалгавар гүйцэтгүүлэх хүсэлт 9, тус шүүхээс даалгавар гүйцэтгэх тухай хүсэлт 25, эвлэрлийн гэрээ баталгаажуулах хүсэлт 175, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт 124 нийт 651 нэхэмжлэл, хэрэг, хүсэлт, гомдлыг хүлээн авч “Иргэн-2014 нэгдсэн систем”-д бүртгэж, 247 албан бичгийг шүүгч, шүүгчийн туслах нарт хүлээлгэн өгч ажилласан байна.



Нийт шүүгчийн чуулганы тогтоолоор баталсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”-ын 2.3, Тус шүүхийн 2022.12.26-ны өдрийн 01 дугаартай “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, Шүүхэд эрүүгийн хэрэг, өргөдөл, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журам, ШЕЗ-ийн 2022.02.24-ний өдрийн 41 дугаартай тогтоолоор баталсан “Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах журам”-ын 6.4, ШЕЗ-ийн 2022.03.04-ний өдрийн 53 дугаартай тогтоолоор баталсан “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-ын 2.5, 3.1.1, 3.1.2, 3.4.2, 3.5, 3.6.1, 3.6.3, 3.16, 3.17.1, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын 2019.12.05-ны өдрийн 246, А80 дугаартай хамтарсан тушаалын нэгдүгээр хавралтын “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан,

битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”-ын 3.2, 3.3, 3.4, 3.5, 4.1, 4.2, 4.5, 4.7, хоёрдугаар хавсралтын “Хавтаст хэргийг шилжүүлэх, хүлээн авах, зөөвөрлөх, хадгалах журам”-ын 3.1-т тус тус заасны дагуу хэрэгжилтийг хангаж эрүүгийн 69 хэрэг, хүсэлт 5, давж заалдах гомдол 19, хяналтын гомдол 8, хянан магдлан 3, хэргийн эд мөрийн баримт 75, албан бичиг 27 нийт 187 хэрэг, хүсэлт, гомдол, эд мөрийн баримт, албан бичгийг хүлээн авч “Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем”-д бүртгэж, шүүгч, шүүгчийн туслахад хүлээлгэн өгч ажилласан байна. Мөн зөрчлийн 248, прокурорын дүгнэлт 38, оролцогчийн гомдол 2, завсарлуулан хэрэг 24, хүсэлт, гомдол 43 нийт 355 хэрэг, гомдол, хүсэлт, прокурорын дүгнэлтийг хүлээн авч шүүгч, шүүгчийн туслах нарт хүлээлгэн өгч ажилласан байна.




2.1.2. ШЕЗ-ийн 2022.03.11-ний өдрийн 58 дугаартай тогтоолоор баталсан “Хавтаст хэрэг илгээх, хүлээн авах журам”-ын 4.1-т заасны дагуу Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүхэд хянагдсан, адил шатны шүүхээс ирүүлсэн эрүү, иргэн, зөрчлийн хэргийг хүлээн авч, магадлал, тогтоолыг хуулбарлаж, нэгдсэн системийн дагуу хуваарилсан байна. Үүнд: Давж заалдах шатны шүүхэд иргэний 10, эрүүгийн 19, зөрчлийн 14 хэрэг, хяналтын шатны шүүхэд иргэний 5, эрүүгийн 4 нийт 52 хэргийг нэгдсэн системээр хүргүүлсэн бол давж заалдах шатны шүүхээс иргэний 10, эрүүгийн 19, зөрчлийн 14 хэрэг, хяналтын шатны шүүхээс иргэний 5, эрүүгийн 4 нийт 52 хэргийг системээр хүлээн авч, шүүгч нарт хүлээлгэн өгч ажилласан.

Шүүгчийн 2023 оны эхний хагас жилд шийдвэрлэсэн хэргийн тоо
/2022.12.21-2023.06.20-ны хугацаанд ажиллаж байгаа болон ажиллаж байсан бүх шүүгч нар хамаарна/

| № | Шүүхийн Тамгын газрын нэр | Шүүхийн нэр | Шүүгчийн нэр | Шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрүүгийн хэрэг | Эрүүгийн зөрчлийн хэрэг | Иргэний хэрэг | Захиргааны хэрэг |
| 1 | Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх | Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх | Б.Өлзийхишиг | | 15 | 58 | 48 | |
| | | | Ж.Отгонхишиг | | 6 | 44 | 23 | |
| | | | Б.Урнасан | | 11 | 43 | 51 | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

2.1.3. Тус шүүхийн шүүгч нарын 2023 оны шийдвэрлэсэн хэргийн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг судалгаа гаргаж Ерөнхий шүүгчид танилцуулан Шүүхийн ерөнхий зөвлөлд 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр цахимаар хүргүүлсэн байна.

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх нь 2022 оны тайлангийн эцсийн үлдэгдэл 12 хүнд холбогдох 12 хэрэг, 2023 оны 3 дугаар улирлын байдлаар шинээр 60 хүнд холбогдох 46 эрүүгийн хэргийг хүлээн авч нийт 58 хүнд холбогдох 72 эрүүгийн хэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.




2.1.4. Тус шүүхийн шүүн таслах ажиллагааны 1, 2, 3, 4-р улирлын тоон мэдээлэл болон шүүхийн тамгын газраас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар сарын бүрийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын зөвлөгөөнд танилцуулж шүүгч нарын зөвлөгөөнөөс гаргасан шийвэрийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд зохион байгуулсан шүүгч ажилтнуудын 10 удаагийн зөвлөгөөнд танилцуулага мэдээлэл хийж ажилласан байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын
20... оны ... сарын ... өдрийн ... тоот
тушаалаар батлав.

**ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ 2023ОНЫ /I улирал, II улирал, III улирал/ МЭДЭЭЛЭЛ**

**А. Хаягийн хэсэг**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Регистрийн дугаар | 9 | 0 | 3 | 8 | 9 | 7 | 8 |
| Шүүхийн нэр | Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх | | | | | | |
| Аймаг, нийслэл | Завхан аймаг, Тосонцэнгэл сум | | | | | | |

**Б. Үндсэн мэдээлэл**

| Д/д | Үзүүлэлтийн утга | | Мөрийн дугаар | 2022 оны 3-р улирлын дүн |
|---|---|---|---|---|
| А | Б | | В | Г |
| | Тайлангийн үеийн эхний үлдэгдэл | Хэрэг | 1 | 12 |
| | | Хүн | 2 | 12 |
| | | Хуулийн этгээд | 3 | |
| | Нэмж хүлээн авсан | Хэрэг | 4 | 22 |
| | | Хүн | 5 | 31 |
| | | Хуулийн этгээд | 6 | |

2.1.5. Тус шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан мэдээг улирал, хагас бүтэн жилээр гарган Шүүхийн ерөнхий зөвлөлд хугацаанд нь хүргүүлж ажилласан. Тус шүүх нь 2023 оны 03 дугаар улирлын байдлаар эрүүгийн 72, иргэний 278, зөрчлийн 214 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.




2.1.6. Эрүү, иргэний хэргийн систем, програмын хэвийн ажиллагааг хангуулан шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу програмд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилах тохиргоог 2022.12.26-ны өдрийн 01 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын 1.1.А-д заасны дагуу хийж, улирал, хагас, бүтэн жилээр тоон мэдээлэл гаргаж шүүхийн цахим хуудаст байршуулан ажиллаж байна.




2.1.7. Долоо хоног бүрийн баасан гаригт дараа долоо хоногт зарлах хурлын товыг нэгтгэн гаргаж. Тухайн шүүхийн нэгдсэн шүүх хуралдааны товыг 7 хоногийн ажлын сүүлийн өдөрт нэгтгэн цаасан хэлбэрээр гаргаж, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системд бүртгэж, прокурорын газар, цагдаагийн хэлтэс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст хүргүүлж хэвшсэн. Тайлант хугацаанд эрүүгийн 118, иргэний 194, зөрчлийн 119 шүүх хуралдааны тов гарган хүргүүлж ажилласан байна.



2.1.8. Хэргийн оролцогч нарыг зайнаас шүүх хуралдаанд оролцох нөцлөөр хангах Зүүм програмаар 45 удаагийн шүүх хуралд оролцуулан, 3 хэргийн өмгөөлөгчийг өөр шүүхтэй холбож хуралд оролцох боломжоор хангаж өгсөн байна.

2.1.9. Шүүхийн шийдвэрийг цахим хуудас /www.shuukh.mn/-т холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд байршуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд цахим санд эрүүгийн хэргийн 52 шийтгэх тогтоол байршуулахаас 43

шийтгэх тогтоол, иргэний хэргийн 8 шийдвэр байршуулахаас 8 шийдвэр тус тус байршуулсан байна.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ГҮЙЦЭТГЭХ ХУУДАС

2023 оны 12 сарын 05 өдөр Дугаар 2023/ГХ/110 Тосонцэнгэл сум

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 2023/ШЦТ/52 дугаартай шийтгэх тогтоолоор:

1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг шүүгдэгч Б.Энхтуулыг 6 /зургаа/ сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэж,
2. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-т зааснаар шүүгдэгч Б.Энхтуулыг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын төвөөс өөр газарт очихгүй байх хязгаарлалт тогтоож,
3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар Б.Энхтуулд шүүхээс оногдуулсан зорчих эрхийг хязгаарлах ялыг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын төвөөс гадагш зорчихгүй байхаар тогтоож, зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй тохиолдолд хорих ялаар солихыг дурдаж, хяналтдаа байлгахыг Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст даалгаж шийдвэрлэсэн байна.

Иймд шүүхийн шийтгэх тогтоол 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүчин төгөлдөр болсон байх тул гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэх нь зүйтэй байна.

Ялтан: Баян овогт Бүрэндэлгэрийн Энхтуул
Хаяг: Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Улаантолгой багийн Дэнж хорооллын 5-507 тоот
Регистрийн дугаар: ИЦ88111706
Утас: 90191117

Гүйцэтгэх хуудсыг 2023 оны 12 дугаар сарын 05-ний өдөр олгов.

ШҮҮГЧ Б.УРТНАСАН

2.1.10. шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл, эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг холбогдох байгууллага, иргэнд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд иргэний хэргийн шүүгчийн захирамж 913, шийдвэр 220, Ерөнхий шүүгчийн захирамж 162, шүүхийн тогтоол 11, иргэний гүйцэтгэх хуудас 115, иргэний хэрэгт шүүхийн мэдэгдэх хуудас 70, эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол 51, гүйцэтгэх хуудас 106 хүргүүлсэн байна.

2.1.11. Шүүн таслах ажлын төрлөөр холбогдох мэдээллийг бүртгэл, хяналтын нэгдсэн системд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрээр цаг тухайд нь оруулж, бүртгэл хөтлөн, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 276 иргэний нэхэмжлэл, 286 өргөдөл гомдол, 245 зөрчлийн хэрэг, 64 эрүүгийн хэргийн мэдээллийг хүлээн авч бүртгэл хөтөлж, хэргийн хөдөлгөөний нэгдсэн системээс шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд холбогдох мэдээллийг харах, мэдээ тайлан гаргах нөхцлийн бүрдүүлэн ажиллаж байна.



2.1.12. Тайлант хугацаанд давж заалдах шатны шүүх рүү эрүүгийн 14 хэрэг, хяналтын шатны шүүх рүү эрүүгийн 3, нийт 18 хэргийг хавтаст хэрэг илгээх, хүлээж авах журмын дагуу шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан бөгөөд хэрэг хүргүүлэх тухай албан бичигт хэргийн дугаар, шүүгдэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, шүүхийн шийдвэрийн огноо, дугаар, хавтас, хуудасны тоо, хавсаргасан баримтыг тухай бүр дурьдаж явуулсан байна.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024-2025 онд шүүх хуралд оролцох иргэдийн төлөөлөгчийн нэрсийг батлах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.3, "Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 4.2.1, 9.2.22-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхэд 2025-2026 онд шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн нэрсийг 1 дүгээр хавсралтаар батлагсугай.
2. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан зарим шаардлага хангахгүй, шүүх хуралдаанд оролцох боломжгүй талаар холбогдох сумдын Засаг даргын тамгын газраас албан бичгээр хариу ирүүлсэн иргэдийн нэрсийг 2 дугаар хавсралтаар гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсүгэй.
3. Шинээр батлагдсан иргэдийн төлөөлөгчийн нэрсийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу хугацаанд нь хүргүүлэхийн Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн /Л.Золбоо/-д даалгасугай.

ДАРГА Б.ӨЛЗИЙ

2.1.13. МУШтХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан иргэдээс нэрсийн жагсаалтыг гаргаж баталгаажуулж, 2022-2024 онд сонгогдсон 159 иргэний мэдээллийн санг бүрдүүлсэн. 2025-2026 онд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгодсон 330 иргэний нэрсийг холбогдох нутгийн захиргааны байгууллагатай

хамтран нягталж шалган шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 11-р сарын 22-ны өдрийн А/22 тоот тушаалаар баталгаажуулж, ШЕЗөвлөлд хүргүүлэн шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхийг хангуулан ажиллаж байна.




2.1.14. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгөх ажлыг шүүгчийн туслахууд хариуцан хэрэгжүүлж, холбогдох баримтыг хэрэгт хавсарган ажиллаж байна. Тайлант хугацаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцсон 9 иргэнд холбогдох мэдээллийг тухай бүр өгч ажилласан.



2.1.15. Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдааны тов гармагц иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас шүүх хуралдаан бүрд 10 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахимаар эрэмбэлэн тохиолдын журмаар сонгон тамгын газрын даргын тушаалаар батлуулан ажиллаж байна. Энэ хүрээнд шүүгчийн туслахууд шүүх хуралдааны тов гармагч дэд жагсаалтыг гаргаж батлуулж, тайлант хугацаанд нийт 8 иргэдийн төлөөлөгч сонгогдож шүүх хуралдаанд оролцсон байна.



2.1.16. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид зориулсан сургалтыг тус шүүхийн харъяаллын 9 сумаас Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон нийт 159 иргэнд ил захидал хүргүүлэн, Тосонцэнгэл сумын соёлын төвд нэгдсэн байдлаар сургалт, мэдээлэл хийж гарын авлага тарааж ажилласан бөгөөд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд эрх, үүрэг хариуцлагын талаар ойлгомжтой байдлаар сургалт мэдээлэл хийсэн бөгөөд 2024 онд шинээр сонгогдсон иргэдэд тухайн сумдад очиж зохион байгуулах, гарын авлагаар хангах ажлыг хийхээр төлөвлөж байна.




2.1.17. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд болон тойргийн сумдад зохион байгуулсан нээлттэй өдөрлөгийн үеэр иргэд олон нийтэд тухай бүх мэдээлэл өгч ажиллаж байна.

2.1.18. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд тус шүүх дэх эвлэрүүлэн зуучлал нь иргэний эрх зүйн маргаан 169, гэр бүлийн эрх зүйн маргаан 17 буюу нийт 186 хэрэг, өргөдөл хүлээн авснаас 167 хэрэг, өргөдлийг шийдвэрлэж ажилласан байна. Үүний 154 өргөдөлд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа амжилттай явагдаж эвлэрлийн гэрээ байгуулж шүүх рүү шилжүүлж шүүгчийн захирамжаар баталгаажсан. Шүүхээс иргэний хэрэг үүсгэсэний дараа шилжүүлж ирсэн 9 гэр бүлийн, урьдчилан шийдвэрлэх журмаар хандсан 2 гэр бүлийн маргаан, ЭЗ-д шууд хандсан 2 иргэний эрх зүйн маргаанд буюу нийт 13 өргөдөл, хэрэгт эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа амжилтгүй болсон байна. Мөн 13 өргөдөл гаргагч өргөдлөө татан авсан учраас эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулах боломжгүй болж эвлэрүүлэн зуучлагч тэмдэглэл үйлдэн татгалзсан, нийт 6 өргөдөл, хэргийн үлдэгдэлтэй байна.



2.1.19. Тус шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах нөхцөлийг хангах хүрээнд өрөөнд нь давхар хаалга хийж өгсөн бөгөөд тойргийн сумдад томилолтоор ажиллах нөхцлийг хангаж 4 удаа томилолтоор ажиллах нөхцлийн бүрдүүлж, 2023 оны жилийн эцсийн байдлаар "Шүүхийн үйл ажиллагааг сурталчлах өдөрлөг"-өөр тойргийн Их-Уул, Тэлмэн сумдад нүүдлэн ажилласан байна. Мөн Тэс сумын Арц суурь боомтын "Эв модны наадам"-ын үйл ажиллагаанд оролцож шүүхийн үйл ажиллагаа болон эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны талаар танилцуулга хийж ажилласан. Тойргийн сумдаар 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд 7 хоног нүүдлэн ажиллах хугацаандаа нийт 75 өргөдөл хүлээн авч газар дээр нь шийдвэрлэж ажилласан байна.




2.1.20. Тус шүүх дэх эвлэрүүлэн зуучлал нь фэйж хуудас нээж нийт 54 мэдээ, мэдээллийг иргэдэд олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлж, тус шүүхэд явагдаж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг оруулан ажилласан байна. Энэ хугацаанд тус фэйж хуудсаар давхардсан тоогоор нийт 86 иргэн зочилж мэдээ, мэдээлэл авсан байна.

Харъяа сумдын томоохон худалдааны 22 төвүүдтэй утсаар холбогдож ЭЗА-ны талаар мэдээлэл өгч, Их-Уул, Тэс, Нөмрөг, Баянтэс, Тэлмэн, Тосонцэнгэл сумдын 68 хүнс барааны дэлгүүрүүдэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар танилцуулж, холбогдох гарын авлага, боршур тарааж ажилласан байна.



2.1.21. Эвлэрлийн гэрээний төслийг ирсэн өргөдлийн дагуу Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар боловсруулан ажиллаж байна. Гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаас татгалзсан тохиолдолд түүний үндэслэлийг харгалзаж дахин талуудыг дуудан ажиллагааг явуулдаг бөгөөд тайлант хугацаанд 175 эвлэрлийн гэрээг баталгаажуулж, 1 гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаас татгалзсан тохиолдол гарсан бөгөөд энэ нь үнийн дүн зөрүүтэй байсныг залруулж дахин талуудыг дуудаж эвлэрлийн гэрээ байгуулж, шүүхэд шилжүүлж шүүгчийн захирамжаар баталгаажуулсан байна.




2.1.22. ШЕЗөвлөлөөс 2020 ирүүлсэн 5 ширхэг, 2021 ирүүлсэн 1 Dell optiplex 3070 брэндийн компьютерүүдэд ssdM2 хард диск, Dell optiplex 3020 брэндийн 8 компьютерт SSD хард шинээр нэмж суурилуулан хурдыг нь гацалтгүй болгож сайжруулсан бөгөөд 4 принтер болон бусад техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.





2.1.23. Шүүхэд мэдээллийн технологийг ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг тогтмол зохион байгуулж Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем", "Цахим орчинд мэдээ, мэдээлэл түгээх арга болон эх бэлтгэх", "E-mongolia", "E-kids программ ашиглалтын талаар сургалт"-ыг зохион байгууллаа.




2.1.24. Шүүхийн программ хангамж, техник хангамж, сүлжээний аюулгүй байдлыг хангах, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах, холбогдох журам, заавар,

стандарт, аргачлалыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж Иргэн-2014 R210 серверийг нэгдсэн дотоод сүлжээндээ ашиглаж түүнд хандсан хэрэглэгчдийн хэрэгцээтэй файл, өгөгдөл /дата/, баримт, мэдээллийн сан зэргийг тайлант хугацаанд 2 удаа 514GB хэмжээтэй файл архивласан байна.

Тухайн шүүхийн хуучин сүлжээний төхөөрөмж болох switch /сүлжээний төхөөрөмж/-ийг 1000Mbps хурдтай төхөөрөмжөөр switch /сүлжээний төхөөрөмж/ сольж, сүлжээний план зураг шинэчлэн гаргаж, сүлжээний хаягжилтыг шинээр хийгээд байна.



2.1.25. Шүүх хуралдааны бичлэгийг 2013 оноос одоог хүртэл архивлаж байгаа бөгөөд тусгайлан бүртгэлийн дэвтэр хөтөлж шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нараар 7 хоног бүр гарын үсэг зуруулан баталгаажуулдаг бөгөөд хатуу дискэнд 9730 бичлэг архивлагдан шүүхийн серверийн өрөөнд хадгалагдаж байна. 2023 онд шинээр 1187 хурлын бичлэг хадгалсан. Үүнд: /Иргэн 137 хурлын 285, эрүү 145 хурлын 302, зөрчил 282 хурлын 568, цагдан хорих 14 хурлын 28, хянан магадлан 2 хурлын 4 бичлэг байна./


ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус шүүх 2022 оны тайлангийн үлдэгдэл 4, 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар шинээр хүлээн авсан 40 нийт 44 зөрчлийн хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, 48 хүнд шийтгэл оногдуулсан байна. Үүнээс 12 хүнд торгох, 36 хүнд баривчлах шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн байна.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо өмнөх мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.



2.1.26. Тус шүүхийн цахим хуудасны хэвийн ажиллагааг тогтмол хангаж, иргэний хэргийн, зөрчлийн хэргийн, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мэдээ, шүүхийн тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны 01-р улирлын шүүх таслах ажиллагааны мэдээ 2023 оны 3-р улирлын эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны тайлан, 2023 оны 3-р улирлын иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны тайлан, 2023 оны 3-р улирлын зөрчлийн хэргийн шүүн таслах ажиллагааны тайлан, 2023 оны хагас жилийн иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны тайлан, 2023 оны хагас жилийн эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны тайлан, 2023 оны хагас жилийн зөрчлийн хэргийн шүүн таслах ажиллагааны тайлан, эвлэрүүлэн зуучлалын 2023 оны эхний хагас жилийн мэдээний тойм, 2023 оны 03-р улирлын шүүн таслах ажиллагааны тайлан зэрэг тухайн шүүхийн шүүн таслах ажиллагаатай холбоотой мэдээг цахим сайт болон фейж хуудсанд оруулан иргэд олон нийтэд түгээн ажилласан байна.



2.1.27. Тус шүүхэд ашиглагдаж байгаа нийт 34 компьютераас 11 нь актлах, 16 принтерийн 3 нь эвдэрхий, нийт 25 камерын 10 нь эвдэрсэн ба 2023 онд шинээр 5 принтер, 3 нөатбүүк, 4 свийч хүлээн авсан байна. ШЕЗ-өөс ирүүлсэн вирусийн программыг компьютер бүрд

идэвхжүүлэн ажилласан. Мөн Windows Active Directory Domain Service-д албан ёсны антивирусны программ суулгаж мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд 15 антивирусны програмыг 3 шүүгчийн туслах, 2 Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүх хуралдааны заалны 2 компьютер болон мэдээлэл технологийн мэргэжилтэн, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, нягтлан бодогч, архив бичиг хэргийн эрхлэгч, 3 шүүгчийн комьютерт суулгаж, интернэт сүлжээний хэвийн, тасралтгүй ажиллагааг хангаж ажилласан.



2.1.28. Шүүхэд ашиглагдаж байгаа программ хангамжийг хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөөг тогтмол өгч ажилладаг бөгөөд шинээр томилогдсон мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, эвлэрүүлэн зуучлагчийн туслах нарт Иргэн-2014 програмын ганцаарчилсан сургалтыг явуулж, шүүхийн нэгдсэн сүлжээг ашиглах талаар мэдээлэл өгч, 3 свич 1 рүтер сольж ажилласан байна.




2.1.29. Шүүхийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, кибер халдлага, хортой код, спам, вирусээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тухай бүр мэдээлэл өгч, шүүхийн имейл хаягт илэрсэн хортой код, спам, вирусыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажиллаж байна. Тайлант хугацаанд тус шүүхийн имейл хаягт ирсэн 3 удаагийн хортой код, вирусээс урьдчилан сэргийлж нээхээс нь өмнө устгаж арилгах арга хэмжээ авч ажилласан байна.

2.1.30. Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол гаргаагүй тул шийдвэрлэлтийн мэдээг гаргаж Ерөнхий шүүгчид танилцуулах арга хэмжээ хийгдээгүй бөгөөд энэ талаар сар бүрийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын зөвлөгөөнд танилцуулж ажилласан.

2.1.31. ШЕЗ болон Монгол шуудан ХК-ны хамтран байгуулсан шуудангийн гэрээний дагуу шүүхийн шуудангийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан битүүмжилсэн тусгай зориулалтын богц бүхий шуудангаа хүлээлгэн өгч шуудангийн сүлжээгээр дамжуулан холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх, гардуулах үйлчилгээг үзүүлж байна. Тайлант хугацаанд нийт 3213 эрх зүйн акт, албан бичгийг шуудpoints хүргэж ажилласан байна.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 01 өдөр | Дугаар А/05 | Тосонцэнгэл сум

Баримт бичиг нягтлан шалгах
комисс шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Шүүхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 87 дугаар зүйлийн 87.1.5, 87.2, Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2019 оны 41, А/03, А/19 тоот захирамж, тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн архивын дэргэд баримт бичиг нягтлан шалгах комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Баттулга /Мэдээлэл технологийн мэргэжилтэн/
Гишүүд: Б.Алтансолонго /Эвлэрүүлэн зуучлагч/
Н.Энхцэцэг /Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн/
Н.Гүнчинсүрэн /Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга/
Нарийн бичгийн дарга: Б.Батхүү /Архив бичиг хэргийн эрхлэгч/

2. Баримт бичиг нягтлан шалгах комисс нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, шүүхийн архивын баримтад хяналт шинжилгээ хийж илэрсэн зөрчлийг арилгуулан тухай бүр илтгэх хуудсаар танилцуулж, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдаж, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулсан "Шүүхийн архивын ажиллах журам"-ыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн "Баримт бичиг нягтлан шалгах комисс шинэчлэн байгуулах тухай" А/13 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.ӨЛЗИЙ

2.1.32. Тус шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулсан бөгөөд архивт хадгалбал зохих хэрэг, баримт бичгийг хүлээн авч, данс, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар тус шүүхийн архивт байнга хадгалах хадгаламжийн нэгж 589 хавтас, түр хадгалах хадгаламжийн нэгж 8,189 хавтас нийт 8,787 хавтаст хэрэг, материал хадгалагдаж байна.



2.1.33. Шүүхийн архивын ажиллах журмын 10.2, 10.2.1, 10.2.3, 10.3-т заасны дагуу. Архивд хадгалагдаж байгаа хэрэг материалаас хуулбарлан гаргах хүсэлтийн дагуу Тамгын газрын даргын зөвшөөрлийн дагуу тендерийн тодорхойлолт 2, хэргээс хуулбар 40, нийт 208,500 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс авч /100900005001/ тоот дансанд тушаасан байна. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/09 дугаартай тушаалаар байгуулагдсан комисс нь нийт 8,787 хадгаламж нэгжийг тоолж, хадгалах хугацаа дууссан 3,602 иргэний хэргийг устгах хэргийн жагсаалт үйлдэж, тооллогын хүрээнд архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа байнга хадгалах 589 хадгаламж нэгж, түр хадгалах 8,189 хадгаламж нэгж, 70 жил хадгалах 70 хадгаламж нэгжүүдийг ангилан төрөлжүүлж хадгаламж тус бүрээр нь ялгаж ажилласан.



2.1.34. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрх олгосоны дагуу Архивын цахимжуулалт хариуцсан гэрээт ажилтныг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулж байгаа бөгөөд 1987-2022 оны шийтгэх тогтоолын өнгөн хувь, 2006-2022 оны шийтгэврийн өнгөн хувь, 1966-2022 оны шийдвэрийн өнгөн хувь, 1978-2022 оны тамгын даргын тушаал, 2003-2017 иргэний хэрэг зэргийг цахим хэлбэрт шилжүүлж тайлант хугацаанд нийт 1800 хэргийг цахим болгоод байна.




2.1.35. Тухайн шүүхийн байранд 2013 оноос хойш их засвах хийгдээгүй байсан бөгөөд 2023 онд тус шүүхийн 60 жилийн ойг тохиолдуулан 14 сая төгрөгийн урсгал засвар хийх шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тогтвортой явуулах нөхцлийг бүрдүүллээ. Их засварын хүрээнд 30 цонхоны дулаалга резин, хавчуурга резин сольж, цонхны тавцангийн дулаан алдаж байгаа хэсэгт хөөс шахаж, цельконоор битүүмж хийсэн. Шүүхийн байрны үүдний хэсгийн нүдэн гэрэл, 1, 2–р давхарын коридор болон шүүх хуралдааны 2 танхим нийт 13 өрөөний 103 ширхэг гэрэлтүүлэг солих ажлыг хийж гүйцэтгэвэл. Дулаан дамжуулах 325м халаалтын шугамыг цагаанаар будаж, шүүхийн байрны өрөө тасалгаа болон шүүх хуралдааны танхим коридорын хэсгийн нийт 870 м/кв талбайд эмульс, 100 м/кв талбайд замаска хийж, гадна үүдний хэсгийн хагарсан шавар, хаягжуулалтын үсгийг засварлаж, гадна үүдний хэсгийг өнгөлгөөний материалаар өнгөлж, шүүхийн таних тэмдэг бүхий гэрэлтүүлэгтэй хаяг шинээр хийсэн байна.



2.1.36. шүүхийн байр, шүүх хуралдааны танхим, өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангаж 2023 оны жилийн эцсийн байдлаар 619 удаагийн шүүх хуралдаан амжилттай явагдаж, цахилгаан тасарсны улмаас 9 удаагийн шүүх хуралдаанд дуу, дууны-дүрсний бичлэг хийгдээгүй байна.



2.1.37. Тус шүүхийн байрны орох хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэдэд зохиулсан налуу замыг стандартад нийцүүлэн хийсэн бөгөөд үүдний хэсгийн дэлгэцнээс холбогдох мэдээллийг сонсох боломжтой чихэвч, нэхэмжлэлийн загварыг томруулж харах боломжтой харааны шил болон линз, сонсголын аппарад байршуулах шүүхийн үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.



2.1.38. Эрүү, зөрчлийн хэргийн эд мөрийн баримтыг яллах дүгнэлтэд тусгагдсаны дагуу нэг бүрчлэн хүлээж авч, гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 34 эрүүгийн хэргийн 72 эд мөрийн баримтыг хүлээн авч хэрэгт дагалдан ирсэн тоног хэрэгсэл, төхөөрөмжийн хэвийн ажиллагаатай эсэхийг нэг бүрчлэн шалгаж, ахуйн хэрэглээний 8 ширхэг эд мөрийн баримт, 10 ширхэг СД-ний бичлэгийг үзэж тоног, хэрэгсэл төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгаж авсан байна.

2.1.39. Шүүхийн тамгын газрын даргын 2022.11.03-ны өдрийн Б/35 дугаартай "Эд мөрийн баримт устгах тухай" тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус комисс шинэчлэн байгуулсан бөгөөд комисс сар бүр хуралдаж, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх талаар мэдээлэл хийж, 4 удаа хуралдаж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.


БАТЛАВ
ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ӨЛЗИЙ

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА И.АМАРТҮВШИН

БОЛОВСРУУЛСАН:
ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭН /Б.БАТТУЛГА/

ТОСОНЦЭНГЭЛ 2020 ОН

2.1.40. Тус шүүхийн тамгын газраас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын төлөвлөгөөг Онцгой байдлын хэлтэстэй хамтран баталсан бөгөөд жил бүр тодотгол хийж байна. Тайлант хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гараагүй бөгөөд шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэн шүүхийн үйлчилгээг хүргэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах арга хэмжээг өдөр тутамд хэрэгжүүлэн ажиллаж байна.


"ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ НИЙТЛЭГ АРГАЧЛАЛ"-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал

Тус журмын 7 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийг нэгдсэн систем болон цахим хуудаст байршуулах талаар зохицуулсан байна.

Тухайн зүйлд "Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам"-ын 4.2-т зааснаас бусад шүүхийн шийдвэрийг байршуулах тохиолдолд хэргийн болон бусад оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгдэж, "Шийдвэрийг цахим хуудаст байршуулахыг мэдэгдэх тухай баримт №12-ыг үйлдэж гарын үсэг зуруулж байх зохицуулалтыг нарийвчлан тусгах санал гаргаж байна.

2.1.41. Хууль зүй, дотоод хэргийн сайд, шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны а/116, 65 дугаар тушаалаар хамтран баталсан "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам" болон "Яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүрэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтанг эрэн сурвалжлах журам"-д дараах зүйлийг нэмж оруулах 1.Орон нутгийн цагдаагийн байгууллага буюу аймгийн цагдаагийн газарт

Шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан орон тооны цагдаагийн офицер ажилладаг боловч тус сумын Цагдаагийн хэлтэст хэв журмын ахлах байцаагч нь Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг давхар хариуцаж байгаа нь учир дутагдалтай байгаа тул шүүх ажиллаж байгаа газар бүрд орон тооны хамгаалалтын офицер ажиллуулах шаардлагатай, 2. “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 3.9.10-ыг “шүүх хуралдааны явцад оролцогчдын зүгээс шүүгч, шүүх бүрэлдэхүүн рүү аюултай байдлаар халдсан, довтолсон бол шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж, уг үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдан довтлогч этгээдийг шүүх танхимаас авч гарах” гэж өөрчлөх; “Иргэдийн төлөөлөгчийг сонгох, тангараг өргөх журам”-д “...шүүх хуралдаанд оролцохоор сонгогдсон иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд оролцох боломжгүй, хүндэтгэн үзэх шалтгаантай байгаа тохиолдолд энэ байдлаа нотолсон баримтаа шүүхэд ирүүлэхийг мэдэгдэж, шаардахад үүнд төдийлөн ач холбогдол өгдөггүй, ирүүлдэггүй. Энэ тохиолдолд шүүгчийн туслах иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнтэй утсаар ярьсан тухай тэмдэглэл үйлдэж хэрэгт хавсаргаж, улмаар дараагийн иргэдийн төлөөлөгчийг сонгож оролцуулах ажиллагаа хийх зохицуулалтыг журмын 3 дугаар зүйлд нарийвчлан тусгах”, “Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал-д “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-ын 4.2-т зааснаас бусад шүүхийн шийдвэрийг байршуулах тохиолдолд хэргийн оролцогчид шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгдэж, баримт №12-ыг үйлдэж гарын үсэг зуруулж байх зохицуулалтыг нарийвчлан тусгах”, “Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал тус журмын 7 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийг нэгдсэн систем болон цахим хуудаст байршуулах талаар зохицуулсан байна. Тухайн зүйлд “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-ын 4.2-т зааснаас бусад шүүхийн шийдвэрийг байршуулах тохиолдолд хэргийн болон бусад оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгдэж, “Шийдвэрийг цахим хуудаст байршуулахыг мэдэгдэх тухай баримт №12-ыг үйлдэж гарын үсэг зуруулж байх зохицуулалтыг нарийвчлан тусгах, журмын 4.5-д “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрсний бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмж /CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт/-д хуулбарлан хадгалах ба түүнд Тамгын дарга тогтмол хяналт тавьж ажиллана” гэж зохицуулсан байна. 7 хоног бүр хадгалах төхөөрөмж /CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт/-д хуулбарлан хадгалах ажлыг ямар албан тушаалтан хийж гүйцэтгэхийг журамд тодорхой заах, журмын 7.8.3-т “Шүүгчийн туслах шүүгчийн захирамж, гүйцэтгэх хуудсыг холбогдох материалын хамт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 185, 186 дугаар зүйлд заасны дагуу харьяалах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд энэ аргачлалын 5.3.2, 5.3.3-т зааснаар хүргүүлнэ.” гэж заасан байна. гэтэл уг журамд 5.3.3 гэж байхгүй тул техникийн шинжтэй алдааг 5.3.1, 5.3.2 гэж засах саналыг, “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-д журмын 5.3.2-т “...Уг тогтоолыг хуульд заасан хугацаанд гардаж аваагүй тохиолдолд хэргийн оролцогчдын хаягаар шуудангаар хүргүүлнэ. Энэ ажиллагааг хийх боломжгүй тохиолдолд тогтоолыг хувилж хэрэгт

хавсарган 3 хоногийн дотор хэргийн хамт анхан шатны шүүхэд хүргүүлнэ.” гэж зохицуулсан байна. Хэрэг дээр тухайн хэргийн оролцогчдын гэрийн хаяг, утасны дугаар тодорхой байхад тодруулаад дээд шүүхийн туслах шуудангаар хүргүүлэх боломж нь бүрэн байна. Тогтоолыг хэргийн хамт ирүүлж байгаа нь хэргийн оролцогчийн эрхийг зөрчиж, мөн шүүгчийн туслах нарт ажлын ачаалал үүсгэж байна. Иймээс “Энэ ажиллагааг хийх боломжгүй тохиолдолд тогтоолыг хувилж хэрэгт хавсарган” гэх хэсгийг журмаас хасах эсхүл гардуулах, хүргүүлэх ажиллагааг хийх боломжгүй тохиолдол гэж ямар тохиолдлыг үзэх эсэхийг тодорхой болгох, журмын 4.3.1-т “Магадлалыг прокурор, оролцогчид энэ аргачлалын 13.14.1-13.15.5-д зааснаар гардуулах буюу хүргүүлнэ” гэсэн байна. Гэтэл уг журамд 13.14 гэж байхгүй тул техникийн шинжтэй алдааг 3.14.1-3.15.5 гэж засах, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх баримтын загвар”-т Зөрчилд холбогдогчид эрх, үүрэг танилцуулсан тухай, шүүгчийн захирамж танилцуулсан тухай, хэргийн материал танилцуулсан тухай, шүүх хуралдааны тов мэдэгдсэн тухай /утас, цахим, албан мессеж/, шийтгэвэр, шүүгчийн захирамжид давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцэл танилцуулсан, хүргүүлсэн тухай, хэргийг эмхэтгэсэн тухай баримтуудыг нэмж батлуулах саналыг гаргаж хүргүүлсэн.



2.1.42. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан 6 удаа онлайнаар сургалтын бэлтгэл хангаж холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан бөгөөд Зүүм програмаар 45 удаагийн шүүх хуралд гаднаас хэргийн оролцогч нарыг оролцуулах ажлыг зохион байгуулж, өмгөөлөгч хэргийн оролцогч нарыг 3 удаа өөр шүүхтэй холбож хуралд нь оролцуулж шүүхийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд буюу 2023 оны 01-р сарын 02-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ний өдрийн хүртэл хугацаанд тус шүүхийн бие даасан байдлыг хангах хүрээнд тухайн шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудтай хамтран олон ажил, арга хэмжээг амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 онд дэвшүүлсэн зорилго, зорилтын дагуу “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх” зорилгоор иргэд олон нийтэд чиглэсэн, шүүхээр үйлчлүүлж буй иргэд ил тод, нээлттэй, түргэн шуурхай, мэдрэмжтэй хандаж шүүхийн захиргааны ажилтан бүр нэг сэтгэл, нэгдсэн зүтгэл гаргаж ажилласан.

2023 онд тус шүүх байгуулагдсаны 60 жилийн ой болж байгаатай холбогдуулан 60 жилийн ойг ажлын өндөр амжилтаар угтах, алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлж дотоод хяналтыг

тогтмол хэрэгжүүлж ажилласан нь үр дүнгээ өгч 2023 оны эхний хагас жилийн хэргийн хөдөлгөөний цахим хяналт, шалгалтаар алдаа зөрчил буурсан үзүүлэлттэй байна.

### 2.2. Шүүхийн хүний нөөцийг удирдах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ӨЛЗИЙД

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу Техникийн гүйцэтгэх болон бага албан тушаалын орон тоог хоёроор нэмж, нийт 19 албан хаагч ажиллуулахыг зөвшөөрөв.

ДАРГА [illegible] Н.ЛУНДЭНДОРЖ

2.2.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт багтаан Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2019 оны 01/1017 тоотын дагуу нийт 19 албан хаагч, 3 шүүгчтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагч байхгүй бөгөөд түр тушаалтай ажиллаж байгаа албан хаагч байхгүй. Тус шүүх нь өвлийн цагт уурын зуухаар халаалтаа шийдвэрлэдэг бөгөөд 3 галч ажиллаж байгаа нь хууль нийцэхгүй байгаа тул Шүүхийн ерөнхий зөвлөлд хүсэлт гаргасны дагуу нэг галчийг ажил гүйцэтгэх гэрээгээр галалгаа зогсох хүртэл ажиллуулах зөвшөөрөл олгосон учир гэрээт ажилтныг оруулаад нийт 24 орон тоотой ажиллаж байна.



2.2.2. Шүүхийн захиргааны ажилтнуудын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын хүрээнд “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д заасны дагуу хувийн хэргийг хөтлөж, хувийн хэргийн бүрдлийг тусгайлан хуудас бүрээр хийж бэлтгэн шинэ хавтаст хийж хадгалж байна. 2023 онд нийт 19 албан хаагч төрийн албан хаагчийн хувийн хэргээ журамд заасны дагуу шинэчилсэн бөгөөд хувийн хэргийг тусгайлсан сейфэнд нууцын журмын дагуу хадгалж, хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 04-ний байдлаа нийт шүүхийн захиргааны 7 ажилтны, үйлчилгээний 12 ажилтны хувийн хэргийг хадгалж байна.



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

БАТЛАВ:
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ӨЛЗИЙ
(Нэр, гарын үсэг, тэмдэг)

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГААНЫ МЭРГЭЖИЛТЭН Н.ЭНХЦЭЦЭГИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | | Эхлэх, дуусах огноо |
|---|---|---|---|---|---|
| | | | эхний хагас жил | сүүлийн хагас жил | |
| 1 | 2 | 3 | 4 | | 5 |
| НЭГ. “ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ БОЛОН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА, ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГААС ХҮССЭН МЭДЭЭЛЛИЙГ ИРГЭН, ХЭРГИЙН ОРОЛЦОГЧ НАРТ ТҮРГЭН ШУУРХАЙ ӨГӨХ, ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ, ХУВААРИЛАХ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ, ШҮҮГЧ, ТАМГЫН ГАЗРААС ГАРГАХ ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭГ ТУХАЙ БҮРТ ГАРГАХ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ, ТАМГЫН ГАЗРААС ӨГСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВРЫГ ГҮЙЦЭТГЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД /Албан тушаалын зорилго, зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт/ | | | | | |
| 1. | **Арга хэмжээ №1.1.** Нийт шүүгчийн чуулганы 2021.10.11-ний өдрийн 05 дугаартай тогтоолоор баталсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”, Тус шүүхийн 2021.12.24-ний өдрийн 01 дугаартай “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол”, ШЕЗ-ийн 2022.02.24-ний өдрийн 41 дугаартай тогтоолоор баталсан “Хэргийн хөдөлгөөний | Хэрэг хуваарилах тогтоол, журмуудын дагуу иргэний иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авах ажиллагааг алдаа зөрчилгүй хийж гүйцэтгэсэн байх | Иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг “Иргэн-2014” нэгдсэн системд алдаа гаргахгүй, үнэн зөв бүртгэж хуваарилагдсан шүүгч, шүүгчийн туслахад хүлээлгэн өгнө. | | 2022.12.21-2023.12.22 |

2.2.3. Тус шүүхийн тамгын газрын дарга шүүхийн захиргааны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт болон 2023 оны шүүхийн тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Төрийн захиргааны 7 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн үйлчилгээний 11 ажилтны үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан

баталгаажуулж, биелэлтийн явцын ярилцлагыг 04 дүгээр сарын 05 болон 10 дугаар сарын 05-ны дотор явуулж, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 06 дугаар сарын 15 болон 12 дугаар сарын 20-ны дотор хийж, үнэлгээг баталгаажуулж байна.


ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 01 өдөр    Дугаар Б/23    Тосонцэнгэл сум

Ажлаас чөлөөлж ажилд
түр томилох тухай

Монгол улсын Шүүхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 87 дугаар зүйлийн 87.1.2, 87.1.5, 87.2, Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.2, 27.3, Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 24 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 05/12184 дугаар албан тоот, Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 9.2.4, 9.2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус шүүхийн тамгын газрын Эвлэрүүлэн зуучлагчийн туслах Лхагважавын Золбоог 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөр тасалбар болгон ажлаас чөлөөлж тухайн өдрөөс эхлэн Мэдээлэл лавлагааны мэргэжилтний албан тушаалд түр томилсугай.
2. Эвлэрүүлэн зуучлагчийн туслах Л.Золбоогийн ажлыг хүлээн авч, Мэдээлэл, лавлагааны мэргэжилтний ажлыг хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баттулга /Мэдээлэл, технологийн мэргэжилтэн/
Гишүүд: Б.Алтансолонго /Эвлэрүүлэн зуучлагч/
Н.Болдбаатар /Нярав/
Нарийн бичгийн дарга: Б.Батхүү /Архив бичиг хэргийн эрхлэгч/

3. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн Л.Золбоогийн сарын үндсэн цалинг ТЗ-6 зэрэглэлээр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг зохих хувиар тооцож 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Ахлах нягтлан бодогч /Э.Доржналжирмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлын байрны тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажил үүргээ үр дүнтэй, хариуцлагатай хэрэгжүүлж, шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллахыг Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн /Л.Золбоо/-д үүрэг болгосугай

ДАРГА    Б.ӨЛЗИЙ

2.2.4. Шүүхийн тамгын газарт Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тоо гарсан бөгөөд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалтанд тэнцсэн Н.Гүнчинсүрэнг шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд, эвлэрүүлэн зуучлагчийн туслахаар ажиллаж байсан Э.Золбоог мэдээлэл лавлагааны мэргэжилтний албан тушаалд томилон ажиллуулж байна.




2.2.5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хүрээнд 7 хоног бүрийн 3 дахь өдөр спорт зааланд сагсан бөмбөг, гар бөмбөг тоглох цаг авч байгаа бөгөөд хуваарьт хугацаанд хөгжөөнт цэнгээнт уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж байна. Мөн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах хүрээнд 2023 оны 04 дүгээр сард багтаан Эрт илрүүлэгт хамруулан, шаардлагатай эмчилгээ, оношлогоонд хамрагдах цалинтай чөлөө олгож ажилласан. Тайлант хугацаанд шүүхийн захиргааны 3, үйлчилгээний 4 албан хаагчид зайлшгүй шаардлагатай шинжилгээ, оношлогоо болон эмчилгээ хийлгэх 5-10 өдрийн цалинтай чөлөө олгосон бөгөөд 2 шүүгч "Ард даатгал ХХК"–иас нөхөн төлбөр авсан байна.



2.2.6. Тус шүүх байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан ойн арга хэмжээний хүрээнд ШЕЗ-ийн болон УДШ, ХЗДХЯам болон бусад салбарын шагнал, төрийн одон медалийн болзоо шаардлагыг хангаж байгаа шүүгч, шүүхийн захиргааны 16 албан хаагчийг холбогдох шагналд тодорхойлж шагналын материалыг ШЕЗ-ийн Шүүхийн хүний нөөцийн газарт хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар шүүхийн тамгын газрын

шүүхийн захиргааны 16 албан хаагч төрийн болон ШЕЗ, УДШ, ХЗДХЯам, салбарын шагналууд авсан байна.



2.2.7. Тайлант хугацаанд шүүгч нар Завхан аймагт шүүх бүрэлдэхүүнд 2 шүүгч 4 удаа, Архангай аймагт 1 шүүгч 4 удаа очиж ажилласан байна.  Мөн шүүгч 2 удаа тойргийн суманд очиж даалгавар гүйцэтгэх ажиллагаа явуулсан бөгөөд эвлэрүүлэн зуучлагч болон мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, эвлэрүүлэн зуучлагчийн туслах гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тойргийн 4 суманд, дараа нь 6 суманд албан томилолтоор ажилласан бөгөөд тамгын газрын дарга, мэдээлэл технологийн мэргэжилтэн, архив бичиг хэргийн эрхлэгч, нярав гэсэн бүрэлдэхүүнтэй баг 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаатай тойргийн 6 суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж ажилласан бөгөөд томилолтын зардлыг шүүхийн төсвөөс тухай бүр олгож ажилласан байна.



| Албан хаагч | Төлөв | Хүсэлтийн огноо | Тайлбар |
|---|---|---|---|
| Э. Доржналжирмаа<br>Ахлах нягтлан бодогч | Чөлөөтэй | Өдрүүдийн хооронд: 2023-11-23 - 2023-11-24 | Говь-Алтай аймагт мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт өгөх... |
| О. Отгонжаргал<br>Цахим архивын ажилтан | Чөлөөтэй | Өдөр: 2023-11-22 | Эвлэрүүлэн зуучлагчийн туслах О.Отгонжаргал миний бие 2023... |
| Б. Батхүү<br>АБХ эрхлэгч | Чөлөөтэй | Өдөр: 2023-11-22 | 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Завхан аймагт төрийн... |
| Б. Алтансолонго<br>Эвлэрүүлэн зуучлагч | Чөлөөтэй | Өдөр: 2023-11-17 | Эвлэрүүлэн зуучлагч Б.Алтансолонго миний бие 2023... |
| Б. Баттулга<br>Мэдээлэл технологийн... | Чөлөөтэй | Өдөр: 2023-11-13 | Завхан аймгийн Түдэвтэй сумд очиж өвлийн идэш ээ гаргах мал... |
| Л. Золбоо<br>ЗЗ туслах | Чөлөөтэй | Өдрүүдийн хооронд: 2023-11-02 - 2023-11-02 Цаг: 08:55-18:05 | Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн Л.Золбоо миний би... |
| Б. Энхриймаа<br>Шүүгчийн туслах | Чөлөөтэй | Өдрүүдийн хооронд: 2023-10-27 - 2023-10-27 | Миний бие Улаанбаатар хотод хуульчийн мэргэжлийн шалгалта... |

Нийт 31 15/хуудас ‹ 1 2 3 › Очих 1

2.2.8. Монгол Улсын шүүхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шүүгчид 141/ЗТ2023/00002, 141/ЗТ2023/00015, 141/ЗТ2023/00029, 141/ЗТ2023/00034, 141/ЗТ2023/00036, 141/ЗТ2023/00054 дугаартай шүүгчдын зөвлөгөөний тогтоолоор 6 удаа чөлөө олгосон бол Шүүхийн захиргааны 19 ажилтанд 1-3 өдрийн цалинтай чөлөөг Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем “ERP” болон чөлөөний хуудсаар олгосон байна.

2.2.9. Тайлант хугацаанд тус шүүхийн шүүгч нар  албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодод гэмтэл, эрүүл мэндэд хохирол учирсан, нас барсан тохиолдолд гараагүй бөгөөд энэ хүрээнд ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 04 өдөр Дугаар Б/21 Тосонцэнгэл сум

Урамшуулал олгох тухай

Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.5, 87.2, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.11, 16.5.5, Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 5.1.11, 9.2.22, Хөдөлмөрийн дотоод журмын 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус шүүхийн тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт ажлын тайлан, үр дүнг үндэслэн эрхэлсэн ажилдаа амжилт гарган гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ хангалттай биелүүлсэн шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилтан албан хаагчдад хавсралтад заасны дагуу үндсэн цалингийн 0,8 хүртэл хувиар үр дүнгийн урамшуулал олгосугай.

2. Шагнал урамшууллыг төсвийн зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Э.Доржналжирмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ӨЛЗИЙ

2.2.10. Шүүхийн захиргааны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, идэвхижүүлэх хүрээнд тэдгээрээс гаргаж буй шинэ санал санаачлагыг дэмжин ажиллаж үр дүнд хүрсэн ажил, арга хэмжээ санаачлан зохион байгуулсан албан хаагчид нэмэлт оноо өгөх, ажлын үр дүн гүйцэтгэлд оруулан тооцож, үр дүнгийн урамшуулал болон үр чадварын нэмэгдэл олгох, шагналд нэр дэвшүүлэх

зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Тайлант шүүхийн захиргааны 16 ажилтанг төрийн болон салбарын шагналаар шагнаж урамшуулсан бөгөөд 3 ажилтаны зэрэг дэвийг нэмэгдүүлж, 2 ажилтанд шинээр зэрэг дэвийн нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлүүлж, 2023 оны эхний хагас жилийн ажлын үр дүнд үндэслэн 16 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгож, шүүхийн үйлчилгээний 6 ажилтанд ур чадварын нэмэгдлийг холбогдох дүрэм журмын дагуу олгосон байна.



2.2.11. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа бөгөөд тус шүүхийн захиргааны ажилтнуудын хүйсийн харьцааг 11 эрэгтэй, 13 эмэгтэй ажилтантай бөгөөд хүйсийн харьцааг тэнцвэртэй байх нөхцлийг хангаж ажиллаж байна. Нийт шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын нэгдсэн хуралдаанаар "Хөдөлмөрийн дотоод журам"-д өөрчлөлт оруулж жендерийн эрх тэгш байдлыг хангах талаарх ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан.



2.2.12. Шүүхийн захиргааны ажилтнуудын ажлын гүйцэтгэл үр дүнд үндэслэн илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, цаашид дахин давтан гаргуулахгүй байхад онцгой анхаарч заавар, чиглэл өгч, амжилттай сайн ажилласан ажилтнуудыг алдаржуулах, цалин хөлсийн нь нэмэгдүүлэх, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох зэрэг ажлыг зохион байгуулж байна. 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үнэлж үндсэн цалингийн 40 хүртэл хувиар үр дүнгийн урамшуулал олгосон.

2.2.13. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэсэн бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар тус шүүхийн тамгын газрын шүүхийн захиргааны 7, үйлчилгээний 10 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг аргачлалын дагуу үнэлж, дүгнэж ажилласан. 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг МУ-ийн Засгийн газраас шинэчлэн баталсан журам, холбогдох аргачлалын дагуу 12 дугаар сарын 20-ны дотор үнэлж дүгнэхээр төлөвлөж байна.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 26 өдөр Дугаар А/19 Тосонцэнгэл сум

Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1, 87.2 дахь заалт, Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 9.6 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2 дахь хэсгийн тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус шүүхийн тамгын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий орон тооны бус "Ёс зүйн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга: Н.Гүнчинсүрэн /ШХНБДарга/
Гишүүд: Б.Алтансолонго /Эвлэрүүлэн зуучлагч/
Л.Золбоо /Эвлэрүүлэн зуучлагчийн туслах/

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг ёс зүйн зөвлөл /Н.Гүнчинсүрэн/-д даалгасугай.

3. Ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулж буй ажилд идэвхитэй оролцож, шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм, төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллахыг нийт ажилтан албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА Б.ӨЛЗИЙ

2.2.14. Шүүхийн тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар даргаар Н.Гүнчинсүрэн /шүүх хуралдааны нарийн бичгийн дарга/, гишүүд Л.Золбоо /мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, Б.Алтансолонго /эвлэрүүлэн зуучлагч/ нарын бүрэлдэхүүнтэйгээр ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулсан бөгөөд шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байна. Тайлант хугацаанд тус шүүхийн захиргааны ажилтнуудтай холбоотой ямар нэгэн өргөдөл, гомдол ирээгүй бөгөөд ёс зүй, сахилга хариуцлага алдсан, сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан байхгүй байна.



2.2.15. Тус шүүхийн тамгын газарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан үйлчлэгч Д.Даваажаргалыг шинэ жил болон Цагаан сарын баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг өгч хэвшсэн бөгөөд шүүхийн захиргааны ажилтны холбооны татварыг сар бүрэн төлж татварын өглөггүй ажиллаж байна.



2.2.16. Эвлэрүүлэн зуучлалаас тойргийн сумдад нүүдлэн ажиллахад тамгын газраас ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн дүүрэн хангаж ажилладаг бөгөөд эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд онцгой анхаарч ШЕЗөвлөлөөс зохион байгуулж буй сургалтанд тогтмол хамруулж, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.



2.2.17. Шүүхийн хүний нөөцийн программд үүсгэсэн бүртгэлийн мэдээллийг шүүгч, ажилтанд журам заасны дагуу нээснээс хойш ажлын 3 өдрийн дотор танилцуулан ажиллаж байна. 2023 онд шинээр орсон О.Отгонжаргал, Б.Ариунжаргал нарын мэдээллийг 3 хоногийн дотор оруулж танилцууллаа. Тайлант хугацаанд 3 шүүгч, тамгын газрын дарга болон шүүхийн

захиргааны 19 ажилтны мэдээллийг нягтлан шалгаж баталгааны хуудсанд гарын үсэг зуруулан ШЕЗ-д хүргүүлдэг бөгөөд програм дахь шүүгч, ажилтны бүртгэл, мэдээлэлд тухай бүр баяжилт хийж тухай бүрд, баримт бичгийн хуулбарлан /PDF/ болгон оруулж байна.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд шүүхийн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэргэшсэн шүүхийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, ажлын байрны болон хамт олны дунд сургаж хүмүүжүүлэх бодлого барьж ажилласан нь үр дүнд хүрч шүүхийн захиргааны 2 ажилтан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зарласан албан тушаалын тусгай шалгалтанд тэнцэж төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөж шүүхийн шүүн таслах ажиллагааны нэг хэсэг болон ажиллаж байна.

Мөн шүүхийн хүний нөөцийн програмын ашиглалт, нөхөн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж шүүхийн захиргааны 18 ажилтны хувийн хэргийг шинэчлэн гаргуулж, холбогдох мэдээллийг бүрэн гаргуулан авч хадгалалт, хамгаалалтын шинэчлэн ажиллаж байна.

Тус шүүхийн 60 жилийн ойг тохиолдуулан холбогдох болзол шаардлагыг хангасан шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг төрийн болон салбарын шагналаар шагнуулахаар баримт материалыг ШЕЗ-д хүргүүлэн нийт 1 шүүгч, 12 ажилтан төрийн болон салбарын шагналаар шагнагдсан нь шүүхийн захиргааны ажилтнуудын итгэл зүтгэлийг үнэлсэн, цаашид хийх бүтээх хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлсэн томоохон арга хэмжээ болсон юм.

### 2.3. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ



2.3.1. Тус шүүхээр эрүүгийн хэргийн 155, иргэний хэргийн 175, зөрчлийн хэргийн 280, нийт 615 шүүх хурал явагдаж, 2139 оролцогчдод шүүх хуралдааны дэгийг танилцуулж, "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-д заасны дагуу шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.




2.3.2. Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт гаргах хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Цагдаагийн байгууллагатай хамтарсан сургалтаар "Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт гаргах" талаар мэдээлэл өгч ажилласан. Тайлант хугацаанд шүүгчийн эрх ашгийг зөрчсөн,

хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс ямар нэгэн гомдол, хүсэлт ирүүлээгүй.

2.3.3. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасанаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүн, аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх тохиолдол гараагүй тус Шүүхийн ерөнхий нэн даруй мэдэгдэх тохиолдол гаргаагүй.

2.3.4. Тайлант хугацаанд шүүгчид хууль ёсны эрх ашгаа хамгаалахаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад тайлбар, хүсэлт гаргах, нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт тохиолдол байхгүй тул Ерөнхий зөвлөлд уламжлах ажиллагаа хийгдээгүй.

2.3.5. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд гараагүй тул уг шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг дангаараа болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албатай хамтран хэрэгжүүлэх тохиолдол гаргаагүй.




2.3.6. Тус шүүхийн 3 шүүгчид 2019 онд бие хамгаалах хэрэгсэл “Цахилгаан бороохой” олгосон бөгөөд хэвийн ажиллаж байгаа бөгөөд тухайн бие хамгаалах тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалтад тухай бүр хяналт тавьж, 2020, 2021, 2023 онд цагдаагийн байгууллагаас цахилгаан бороохой ашиглах сургалт мэдээлэл хийж, гарын авлага олгосон байна.

2.3.7. Тайлант хугацаанд шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд ямар нэгэн хамгаалалтын арга хэмжээ авч, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажилласан тохиолдол гаргаагүй.


ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр — Дугаар 2023/ШТ/09 — Тосонцэнгэл сум

Шүүх хуралдааныг хойшлуулж,
гэрчийг албадан ирүүлэх тухай

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн шүүгч Б.Уртнасан даргалж, шүүгч Б.Өлзийхишиг, Ж.Отгонхишиг нарын бүрэлдэхүүнтэй,
Прокурор Н.Баасанжав,
Иргэдийн төлөөлөгч О.Эрдэнэцэцэг,
Шинжээч П.Базардаргиа, Ө.Сарангэрэл,
Гэрч Г.Ганбаяр,
Шүүгдэгч Г.Буяннэмэхийн өмгөөлөгч С.Энхболд,
Шүүгдэгч Б.Пүрэв-Очирын өмгөөлөгч М.Гомборагчаа, Э.Ганбат
Шүүгдэгч Г.Буяннэмэх, Б.Пүрэв-Очир нарыг оролцуулан,
Нарийн бичгийн дарга Б.Батбаяраар тэмдэглэл хөтлүүлэн тус шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны танхимд нээлттэй явуулсан шүүх хуралдаанаар Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.11-т заасныг яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Г.Буяннэмэх, Б.Пүрэв-Очир нарт холбогдох 2224000000070 дугаартай хэргийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүх хуралдаанд оролцогч талууд нь хохирогч Б.Оюундэмбэрэл, гэрч Л.Лхагвасүрэн нарыг шүүх хуралдаанд оролцуулах, гэрч Л.Лхагвасүрэнг албадан ирүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах санал хүсэлтүүдийг тус тус гаргасан болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д "...Шүүх хуралдаанд оролцвол зохих тал, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулж болно..." гэж, 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "гэрч, хохирогч... шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол шүүх өөрийн санаачилгаар, эсхүл прокурорын хүсэлтийн дагуу албадан ирүүлэх шийдвэр гаргана." гэж тус тус хуульчилсан.

Хохирогч Б.Оюундэмбэрэл нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхэд ирж чадаагүй талаараа болон шүүх хуралдаанд оролцох хүсэлттэй байгаа талаараа шүүхэд утсаар мэдэгдсэн байна.

Харин гэрч Л.Лхагвасүрэнд шүүх хуралдааны товыг хуульд заасны дагуу мэдэгдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй байна.

Иймд шүүх хуралдааныг хойшлуулж, гэрчийг албадан ирүүлэх талаар шүүх хуралдааны оролцогчдын хүсэлтийг хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

0000000128

2.3.8. Тус шүүхээр 2023 онд эрүүгийн хэргийн 155, иргэний хэргийн 175, зөрчлийн хэргийн 280, нийт 615 шүүх хурал явагдаж, 2139 оролцогчдод шүүх хуралдааны дэг сахиулан ажилласан бөгөөд шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангаж, шүүхээс оргон зайлсан яллагдагч,

шүүгдэгч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг эрэн сурвалжлах 13, албадан ирүүлэх 20 нийт 33 захирамж, шийдвэр хүлээн авч 20 албадан ирүүлэх захирамжийг биелүүлсэн байна. ШШГХ-ийн цагдан хорих байрнаас шүүхэд 35 удаа, шүүхээс ШШГХ-н цагдан хорих байранд 53 удаа яллагдагч, ялтан, шүүгдэгчийг 88 удаа, ердийн журмаар, албаны тээврийн хэрэгслээр, маршрутын дагуу 528 км зам туулж хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэж ажилласан. Мөн зөрчлийн хэргийн шүүх хуралдаанаар баривчлах шийтгэл оногдуулсан 170 этгээдийг цагдаагийн хэлтсийн баривчлах байранд хүргэж, хүлээлгэн өгч ажилласан.




2.3.9. Шүүх, шүүхийн байрны гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэсэн, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, байгалийн аюулт үзэгдэл, осол, гамшиг гарсан тохиолдол гаргаагүй бөгөөд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.





2.3.10. Шүүхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд харуулын цагдаа дээр дуудлагын хонх байрлуулсан бөгөөд шүүхийн хаалгаар орж гарч буй тохиолдолд мэдээлэл өгөх хонхыг суурилуулан шүүхийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, онцгой нөхцөлд ажиллах ажилтны нэрсийг шүүхийн харуулын цагдаад өгч, шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд танилцуулан ажиллаж байна.



2.3.11. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад цагдаагийн байгууллагатай хамтран 2023 оны эхний хагас жилд нэг удаа сургалт зохион байгуулсан.

2.3.12. Тайлант хугацаанд өөрийн амьдарч байгаа орон байранд галын аюулгүй байдал, гэмт халдлагаас хамгаалагдсан эсэхэд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах тухай шүүгч нараас хүсэлт ирүүлээгүй бөгөөд мэргэжлийн байгууллагад хандсан тохиолдол гараагүй.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын аюулгүй байдлыг бүрэн хангуулж, шүүх хуралдааны оролцогч нарт шүүх хуралдааны дэгийг ойлгомжтой байдлаар танилцуулж, шүүгч, шүүх бүрэлдэхүүний шийдвэрийн биелэлтийг хангуулах, шүүхийн тогтоол шийдвэр цаг хугацаандаа гарах, иргэдийн зөрчигдсөн эрхийг хангаж хамгаалах ажлыг хуульд заасны дагуу ил тод, түргэн шуурхай хэрэгжүүлэхэд шүүхийн тамгын газраас бүхий л нөхцөл боломжоор хангаж, цагдаагийн байгууллагаас холбогдох сургалт, мэдээллийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд шүүгчийн хараат бус байдалд халдсан, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлсөн, нөлөөлөхийг оролдсон тохиолдол гараагүй, шүүгч нараас нөлөөллийн мэдүүлэг хөтөлж ирүүлээгүй бөгөөд шүүхийн тамгын газраас цагдаагийн байгууллагатай нягт хамтарч ажиллаж байгаа нь үр дүнд хүрч байна гэж үзэж байна.

### 2.4. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

2.4.1. Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг тус шүүхийн сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны зардал, зах зээлийн үнийн өсөлт, бараа материалын үнэ ханш, бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, үндэслэл, журмын дагуу боловсруулан Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

2.4.2. Жилийн эцсийн байдлаар 725,647,000 төгрөгийн санхүүжилт буюу цалин хөлс 430,878,600, ажил олгогчоос НД төлөх шимтгэл 50,941,900, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 17,678,800, хангамж бараа материалын зардалд 38,177,100, нормативт зардал 448,800, эд хогшил урсгал засвар 30,517,400, томилолт зочны зардал 10,535,500, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 11,940,700 төгрөгийг улсын төсвөөс авч нийт санхүүжилтийн 87,3%-ийг төсвийн зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулан ажиллаж байна.

2.4.3. Цалин хөлсийг МУ-ын Засгийн газрын 2022 оны 05-р сарын 11-ны өдрийн 192,193-р тогтоолыг баримтлан тооцоолж байгаа ба батлагдсан цалингийн сан, орон тоонд багтаан цалин хөлсийг ТАЦНС-ээр цалинг тооцоолон олгож буй бөгөөд тайлант хугацаанд үндсэн цалинд 369.3 сая, нэмэгдэлд 117.8 сая, унаа хоолны хөнгөлөлтөд 20.3 сая, урамшуулалд 16.6 сая төгрөг нийт 524 сая төгрөгийн цалинг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгож санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны цалингаас холбогдох татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, өр, авлагагүй ажиллаж байна.

2.4.4. Тус шүүхийн тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчид чухал шаардлагтай мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацааны дотор гарган ажиллаж байна. Тайлант хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү

хөрөнгө оруулалтын газарт 2024 оны төсвийн төсөл, шүүхийн захиргааны ажилтнуулын цалингийн судалгаа болон захиргааны албан тушаалтнуудын цалингийн нэмэгдлийн судалгааг гаргаж хүргүүлсэн байна.

2.4.5. Нягтлан бодох бүртгэлийн дагуу анхан шатны баримт /төлбөрийн хүсэлт, нэхэмжлэл, зарлагын баримт, е-баримт/-ын бүрдлийг хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Байгууллагын галлагаанд 11 сая төгрөгийн түлээ, нүүрс , 14,5 сая төгрөгийн бензин шатахуун, байгууллагын хог ачуулсан 316, 2 мянган төгрөгийн, 4,5 сая төгрөгийн аж ахуйн материал, 18,2 сая төгрөгийн засварын материал, 8,7 сая төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авах ажиллагааны анхан шатны баримтыг бүрдлийг бүрэн хангуулан ажилласан байна.

2.4.6. Тайлант хугацаанд тус шүүхийн тамгын газраас /www.tender.gov.mn/ цахим хуудсыг ашиглан худалдан авах ажиллагаа явуулаагүй.




2.4.7. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд /www.shilendans.gov.mn/ цахим хуудаст 2022 оны бүтэн жилийн тайлан, 1, 2, 3-р улирлын тайлан болон сар бүрийн санхүүгийн тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулан ажиллаж байна. 2023 онд нийт 163 мэдээлэл оруулах ёстойгоос 117 мэдээ, тайланг шилэн дансанд үнэн зөв хуулийн хугацаанд хугацаа хоцроолгүй байршуулан ажилласан.

2.4.8. Тус шүүхийн тамгын газраас төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн ажиллаж байна.

2.4.9. Шүүхийн эд хөрөнгийг хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн программаас хэвлэсэн эд хариуцагчийн картын дагуу эд хөрөнгөтэй тулган тооллого хийж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан тус бүрийн эд хөрөнгийг нүдээр үзэн тулган тоолж, баталгаажуулан эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр явуулж байна.

2.4.10. МУ-ын Их хурлаас баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах ажиллагаа хийгдээгүй бөгөөд батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулан ажиллаж байна.

2.4.11. Тус шүүхийн эд хөрөнгийг шинээр бүртгүүлэх, бүртгэлээс хасах, ашиглалтын хугацаа дууссан, хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, устгах саналыг төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх жагсаалт гарган ШЕЗ-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

2.4.12. Тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, гарын авлага, бичиг хэрэгсэл /бичгийн цаас, принтерийн хор/ зэрэг бусад шаардлагатай материалаар хангах ажлыг зохион байгуулж 2023 оны жилийн эцсийн байдлаар хангамж бараа материалын зардалд 38,1 сая төгрөгийн зардал гаргасан байна.




2.4.13. Тухайн шүүхийн тамгын газар нь 2 автомашинтай бөгөөд Renault Duster маркын автомашиныг 2021 орж Шүүхийн ерөнхий зөвлөлөөс олгосон. Тоёота Прадо-150 маркын автомашиныг 2013 онд хүлээн авсан бөгөөд засвар үйлчилгээ тогтмол хийгдэж байна. Тайлант хугацаанд Прадо-150 автомашин нь томилолтоор ажиллах замд моторт эвдрэл гарч моторын ком жийрэг солих засварын ажил хийгдсэн. Renault Duster маркын автомашины духны ремин суларч тос гоожсон тул Моннис ХХК-ийн засварчид ирж засвар үйлчилгээ хийж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

2.4.14. Тухайн шүүхийн 2 автомашиныг тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг, тооллогод тухай бүр бэлтгэн үзлэгт хамруулдаг бөгөөд автомашины ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж байна. Прадо-150 автомашин нь 2023 оны 03 дугаар сард тойргийн суманд томилолтоор ажиллах үеэр тос масло нь холилдож эвдэрсэн байсан тул тухайн суманд 2023 оны 05 дугаар сард явагдсан автотээврийн үзлэг, оношлогоонд хамрагдаж чадаагүй байна.

2.4.15. Тус шүүхийн тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, эрүүл мэнд, нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татварын тайланг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлэн ямар нэг алдаа зөрчилгүй ажиллаж байна.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах хүрээнд Төрийн хэмнэлтийн хуулийг дагуу төсвийг эдийн засгийн ангилалын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулан ажиллалаа.

Шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тогтвортой явуулах шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгох, холбогдох татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцох, албан томилолтоор ажиллах үеийн томилолтын зардлыг тооцох, шүүхийн байрны халаалт дулаан, цахилгааныг тогтвортой байлгах, автомашины бэлэн байдлыг хангуулах, шүүхийн захиргааны ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, үр дүнгийн болон ур

чадварын нэмэгдлийг зөв шударга тогтоож олгох, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын ажиллах орчныг сайжруулах, чухал шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх зэрэг ажил, үйлчилгээнд анхаарал хандуулан ажилласан.

Тайлант хугацаанд төсөв санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хуульд заасан хугацаанд нь хүргүүлэх, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулах, сар бүрийн санхүүжилтийг чухал шаардлагатай зүйлд зарцуулж, тус шүүхийн 60 жилийн ойг тохиолдуулан шүүхийн байранд их засварын ажлыг шүүхийн захиргааны ажилтнуудын хүчээр хийж гүйцэтгээд байна.

### 2.5. Мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ




2.5.1. Тус шүүхийн вэб сайт, “Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар” нэртэй Facebook хуудсанд шүүхээс үзүүлж буй үйлчилгээ, шүүхийн шинэтгэлийн талаарх мэдээллийг тухай бүр байршуулж шинээр 47 удаа мэдээлэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим сайтад тавигдсан 11 удаагийн мэдээ, мэдээлэл тус шүүхийн шүүн таслах ажиллагааны 11 мэдээллийг тогтмол хүргэж ажиллалаа. Мөн шүүхийн байрны гадна байрлах мэдээллийн самбарт шүүн таслах ажиллагааны тойм мэдээ, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мэдээ болон шүүхийн шүүх хуралдааны тов, тойм зэргийг тогтмол байршуулан иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан.



2.5.2. Тус шүүхийн тамгын газрын цахим хуудаст шүүхийн тамгын газрын хүний нөөцийн талаарх мэдээллийг байршуулсан бөгөөд, тухайн шүүхийн тамгын газрын шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллаж байна. Шилэн дансанд нийт 163 мэдээ, мэдээлэл оруулахаас Хуулийн хугацаанд нийт 117 мэдээллийг хуулийн хугацаанд оруулсан.




2.5.3. Тус шүүхээс иргэд олон нийтэд чиглэсэн үйлчилгээний төрөл, шаардагдах баримт бичгийн жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар 141 хүн тухайн мэдээлэлтэй танилцсан байна.



2.5.4. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020.09.01-ний өдрийн 102 дугаар тушаалаар баталсан “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх, цахим систем ашиглах журам”-ын 1.6.2, 3.1.4-т заасны дагуу Иргэний хэргийн шүүх хуралдааны 195, Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 125, Зөрчлийн хэргийн шүүх хуралдааны 121, Цагдан хорих хурлын 10, Хянан магадлангийн 3 нийт 454 товыг тухай бүр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажилласан.




2.5.5. Эрүү, иргэний хэргийн систем програмын хэвийн ажиллагааг хангаж, тухайн програмд шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хэрэг хуваарьлах тохиргоог 1 хийж шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг цахим хуудаст байршуулан ажиллаж байна.




2.5.6. Эвлэрүүлэн зуучлалын нээлттэй утас 70468086 дугаар байнга ажиллаж байгаа бөгөөд өдөр тутмын дуудлагын тэмдэглэл хөтөлж давхардсан тоогоор 84 дуудлага хүлээн авч иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан байна.

Байгууллагын гадна талын мэдээллийн самбарт нийт шүүх хуралдааны тов болон иргэдэд өгөх эрх зүйн мэдээллийг байршуулж, шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар пэйж хуудас нээж, тойргийн сумдын иргэдийн facebook групт шторк, болон шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол мэдээлж байна.




2.5.7. Шүүхэд гаргах нэхэмжлэлийн загвар, бүрдүүлбэр, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх банкны дансны дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас, байршуулж шинэчлэл өөрчлөлтийг тухай бүр хийж байна.




2.5.8. Тус шүүхийн тамгын газрын 2014-2022 оны үйл ажиллагааны тайланг өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийг шүүхийн үйл ажиллагаатай ил тод нээлттэй танилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



2.5.8. Хуульд тусгайлан зааснаас бусад нээлттэй шүүх хуралдааны үйл ажиллагааг үзэж сонирхох боломжийг олгож тухайн шүүхэд явагдаж буй нээлттэй хуралдааныг шүүхийн үүдний дэлгэцээр дамжуулан гаргадаг бөгөөд иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн ажилтныг шүүх хуралдааны дэгд заасны дагуу оролцуулах боломжоор хангаж ажиллаж байна. Тайлант хугацаанд тухайн сумын Ерөнхий боловсролын 1, 2-р сургууль болон МСҮТөвийн ахлах ангийн 47 сурагч, Тарвагатайн нурууны тусгай хамгаалалтын захиргааны 7 ажилтан албан хаагчид шүүхийн үйл ажиллагаатай танилцаж нээлттэй шүүх хуралдаанд биечлэн оролцсон.




2.5.9. Тус шүүхээр хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж “Айлгах гэж буудаад хүний амь хохироов”, “Хохирол, хор уршгийн талаар шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр байхад иргэний хуулиар дахин шийдвэрлэх боломжгүй” тухай хэрэг маргааны талаар иргэд олон нийтэд тус шүүхийн цахим сайт болон фейж хуудсаар мэдээлэл түгээж ажиллалаа.

2.5.10. Тайлант хугацаанд төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлэх тухай хүсэлт ирүүлээгүй бөгөөд ямар нэгэн телевиз болон цахим сайт, хэвлэл мэдээллийн байгууллагаар шүүх хуралдааны талаар мэдээ, мэдээлэл гараагүй.




2.5.11. Шүүхийн захиргааны ажилчдын харилцаа хандлага, ёс зүй, ур чадварын талаар хэрэглэгчийн үнэлгээг Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс боловсруулсан асуулгын хүрээнд авлаа. Хэрэглэгчийн үнэлгээг 19-71 хүртэлх насны 30 хүнээс тус бүр 9 асуултаар авч үнэлгээг нэгтгэн дүгнэв. Нийт 30 иргэнээс авсан хэрэглэгчийн үнэлгээг нэгтгэж

үзэхэд тус шүүхийн захиргааны ажилчид харилцаа хандлага, ёс зүй, ур чадвар хэрэглэгчийн үнэлгээгээр ДУНДЖААР 4,1 оноотой, "Ажилтны цаг баримтлах, ашиглах байдал” хамгийн өндөр буюу 4,56 оноо, "Ажилтны асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал” хамгийн бага буюу 3,53 оноо авсан үзүүлэлттэй гарсан байна.




2.5.12. Ерөнхий зөвлөлөөс гарсан шийдвэр тогтоолыг тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах арга хэмжээ авч, шүүхийн захиргааны ажилтнууд мэдээлэл авсан талаар гарын үсэг зурж баталгаажуулдаг бөгөөд тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны талаарх мэдээллийн шүүхийн цахим хаяг болон фейж хуудсанд байршуулж, тойргийн сумдаар ажиллах тохиолдолд иргэд олон нийтэд тухай бүр мэдээлэл өгч ажилласан байна.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд тус шүүх үүсэн байгуулагдсаны 60 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэ хүрээд тус шүүхийн тамгын газраас иргэд олон нийтэд чиглэсэн, шүүхийн үйл ажиллагаа, ололт амжилтын талаар нээлттэй өдөрлөг зохион байгуулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахаар төлөвлөж ажилласан.

Завхан аймгийн Тосонцэнгэл суманд бие даасан шүүх байгуулагдсаны 60 жилийн ойн тохиолдуулан харъяа тойргийн 9 суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, шүүхийн үе, үеийн архивын баримт болон ололт амжилтын талаар үзэсгэлэн гаргаж, 3*3 спортын тэмцээн зохион байгуулж, иргэд олон нийтэд шүүх, шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл өгч ажилласан нь иргэдийн сонирхлыг татсан шүүхийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаар мэдээлэл авсан өндөр ач холбогдолтой арга хэмжээ болж чадсан.

## ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

Тус шүүхийн тамгын газраас Завхан аймгийн Тосонцэнгэл суманд бие даасан шүүх байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан шүүгч, шүүхийн захиргааны ажилтан албан хаагчдын гаргасан санал санаачлагыг дэмжиж, шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тогтвортой, тасралтгүй явуулах, хэргийн хөдөлгөөнд гарч буй алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, шүүгч, ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, шүүхийн байранд их засварын ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлах хийх, шүүхийн үйл ажиллагаа, ололт амжилтыг иргэд, олон нийтэд сурталчлах, шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд чанартай, мэдрэмжтэй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай үзүүлэх зэрэг олон арга хэмжээг амжилттай биелүүлж ажиллалаа.

Бидний үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, түүний ажлын алба, Монгол Улсын дээд шүүхийн тамгын газар болон нутгийн захиргааны байгууллагуудын дарга удирдлагуудад гүн талархал илэрхийлье.

Тус шүүхийн тамгын газар нь 2023 онд шүүх байгуулагдсаны 60 жилийн ойг хүрээнд нэгдсэн нэг санаа зорилготой, итгэл зүтгэлтэй байж төрийн хуулиар хүлээсэн ажил үүргээ нэр төртэй, өндөр хариуцлагатайгаар хэрэгжүүллээ.

Бидний дундаас шүүх байгуулагдсан 60 жилийн ой хүрээнд 1 шүүгч, 12 шүүхийн захиргааны ажилтан төрийн болон салбарын шагнал хүртэж, олон жилийн хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлсэн нь бахархалтай, дурсгалтай үйл явдал боллоо.

Цаашид энэхүү хүрсэн амжилтаа улам бүр бататгаж, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дахин давтан гаргахгүй байх, нэг санаа зорилготой, нэг баг болон ажиллах шаардлага бидний өмнө тулгарч байна.

Тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд бие биеэ гэсэн халуун сэтгэлтэй, тусархуу хамт олон бөгөөд ирж буй 2024 онд дэвшүүлсэн зорилго, зорилтыг хамгийн сайнаар биелүүлэхийн төлөө хамтарч ажиллах шаардлагатай байна.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ӨЛЗИЙ